



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 02 дугаар сарын 08
№ 06 /915/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын Их
Хурлын тогтоол**

232

**Монгол Улсын Их Хурлын болон
аймаг, нийслэлийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
сонгуулийн санал авах өдрийг
тогтоох тухай**

**Монгол Улсын Их
Хурлын тогтоол**

234

**Монгол Улсын Их Хурлын
сонгуулийн тойрог байгуулах,
тойргийн мандатын тоо, дугаар,
нутаг дэвсгэр, төвийг тогтоох
тухай**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн тогтоол**

245

**Шүүх байгуулах тухай
хуулийн 1,2 дугаар зүйлийн
зарим заалт Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн
эсэх маргааныг эцэслэн
шийдвэрлэсэн тухай**



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

57. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 230

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

58. Улс төрийн намын тухай /Шинэчилсэн найруулга/
болон холбогдох бусад хуулийн төслүүдийг
буцаах тухай Дугаар 04 231
59. Агаарын бохирдлыг бууруулах асуудлын
дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт
орлуулах тухай Дугаар 06 231
60. Санхүүгийн зохицуулах хорооны даргын
үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Дугаар 08 232
61. Монгол Улсын Их Хурлын болон аймаг,
нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ээлжит сонгуулийн санал авах
өдрийг тогтоох тухай Дугаар 09 232
62. Монгол Улсын Их Хурлын болон аймаг,
нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2016 оны ээлжит сонгуульд
техник хэрэгсэл хэрэглэх тухай Дугаар 10 233
63. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог
байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар,
нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Дугаар 11 234

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

64. Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон
томилох тухай Дугаар 01 237

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

65. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах
тухай Дугаар 508 237
66. Талбайг нөөцөд авах тухай Дугаар 512 238
67. Журам, тооны хязгаар батлах тухай Дугаар 513 240
68. Дүрэмд өөрчлөлт оруулах тухай Дугаар 530 244

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ТОГТООЛ**

69. Шүүх байгуулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийн
зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг
зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн
тухай Дугаар 01 245



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|-----|---|-----------|-----|
| 70. | Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 01 | 252 |
|-----|---|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“23.2.Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний өдрөөс өмнө, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших бол санал авах өдрөөс гурван сарын өмнө тус тус төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байна. Сонгуульд нэр дэвшихтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Улс төрийн намын тухай /Шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хуулийн төслүүдийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Архивын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, “Улс төрийн намын тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай



хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Цэдэвдамбын Оюунгэрэлийг Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

**Санхүүгийн зохицуулах хорооны
даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 125 дугаар зүйлийн 125.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Загдхүүгийн Нарантуяаг Санхүүгийн зохицуулах хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн
санал авах өдрийг тогтоох тухай**

Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.4, 16.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2016 оны 06 дугаар сарын 29-ний өдөр байхаар тогтоосугай.

2.Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийн Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн саналыг 2016 оны 06 дугаар сарын 17, 18, 19-ний өдрүүдэд авахаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын болон аймаг,
нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2016 оны ээлжит сонгуульд
техник хэрэгсэл хэрэглэх тухай**

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай

Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймаг тус бүрийг нэг, нийслэлийг зургаан тойрог болгож Улсын Их Хурлын сонгуулийн нийт 26 тойрог байгуулсугай.

2. Дорноговь, Говьсүмбэр аймгийг нэгтгэн Улсын Их Хурлын сонгуулийн нэг тойрог болгосугай.

3. Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, тойрог бүрд ногдох Улсын Их Хурлын гишүүний мандатын тоог хавсралтаар баталсугай.

4. Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТОЙРОГ

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Тойргийн төв	Ногдох мандатын тоо
1	Архангай аймаг	Эрдэнэбулган сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
2	Баян-Өлгий аймаг	Өлгий сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
3	Баянхонгор аймаг	Баянхонгор сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2



4	Булган аймаг	Булган сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	1
5	Говь-Алтай аймаг	Есөнбулаг сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	1
6	Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг	Сайншанд сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	1
7	Дорнод аймаг	Хэрлэн сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
8	Дундговь аймаг	Сайнцагаан сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	1
9	Завхан аймаг	Улиастай сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
10	Өвөрхангай аймаг	Арвайхээр сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
11	Өмнөговь аймаг	Даланзадгад сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	1
12	Сүхбаатар аймаг	Баруун-Урт сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	1
13	Сэлэнгэ аймаг	Сүхбаатар сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
14	Төв аймаг	Зуунмод сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2



15	Увс аймаг	Улаангом сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
16	Ховд аймаг	Жаргалант сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
17	Хөвсгөл аймаг	Мөрөн сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
18	Хэнтий аймаг	Хэрлэн сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
19	Дархан-Уул аймаг	Дархан сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
20	Орхон аймаг	Баян-Өндөр сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	2
21	Хан-Уул, Баганхангай, Багануур дүүрэг	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	2
22	Баянзүрх, Налайх дүүрэг	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар	3
23	Сүхбаатар дүүрэг	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар	2
24	Чингэлтэй дүүрэг	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар	2
25	Баянгол дүүрэг	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар	2
26	Сонгинохайрхан дүүрэг	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар	3
ДҮН			48



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Аргентин Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Осорын Эрдэнийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Аргентин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулуунбаатарын Сосормааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 508

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2014 оны 36 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Засгийн газраас зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд баригдсан “Буянт-Ухаа 1” хорооллын орон сууцанд иргэдээс захиалга авах журам”-ын 4.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.3. Орон сууц худалдан авсан төрийн албан хаагч, зорилтот бүлгийн иргэн худалдан авсан орон сууцны зээл, төлбөрийг бүрэн барагдуулсан тохиолдолд уг орон сууцыг бусдад худалдах, түрээслүүлэх эрхтэй болно.”

2. Мөн журмын 6.4, 6.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

З.БАЯНСЭЛЭНГЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 512

Улаанбаатар
хот

Талбайг нөөцөд авах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 13.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нурууны 652527.98 га газар бүхий талбайг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэлийг цэгцлэх зорилгоор 3 жилийн хугацаагаар нөөцөд авч, хилийн заагийг хавсралт ёсоор тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

УУЛ УУРХАЙН САЙД

Р.ЖИГЖИД

Засгийн газрын 2015 оны 512 дугаар
тогтоолын хавсралт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ НӨӨЦӨД АВСАН ТАЛБАЙН СОЛБИЦОЛ

№	Талбайн нэр	Цэгийн дугаар	Солбицол						Талбайн хэмжээ (га)
			Уртраг			Өргөрөг			
			град	мин	сек	град	мин	сек	
1		1	100	42	47.09	43	27	19.81	
2		2	100	47	23.87	43	21	0.08	
3		3	101	4	24.41	43	21	25.07	
4		4	101	4	24.41	43	15	27.87	
5		5	100	59	31.87	43	15	27.87	
6		6	100	59	31.87	43	10	40.08	
7		7	101	4	47.72	43	10	40.08	
8		8	101	4	47.72	43	2	1.29	
9		9	101	2	15	43	2	1.29	
10		10	101	2	15	42	58	47	
11		11	100	58	45.76	42	58	47	
12		12	100	58	45.76	43	3	1.29	



13		13	100	57	47.96	43	3	1.29	
14		14	100	30	0.59	43	3	1.28	
15		15	100	30	0.6	43	4	1.3	
16		16	100	23	0.51	43	4	1.34	
17		17	100	23	0.51	43	3	1.32	
18		18	100	21	0.51	43	3	1.32	
19		19	100	21	0.51	43	2	1.32	
20		20	100	14	0.5	43	2	1.32	
21		21	100	14	0.5	43	1	1.32	
22	Тост, Тосон бумбын нуруу	22	100	12	0.5	43	1	1.31	652527.98 га
23		23	100	12	0.6	42	59	1.27	
24		24	100	16	5.57	42	59	1.27	
25		25	100	16	0.6	42	59	1.26	
26		26	100	16	0.58	42	51	11.12	
27		27	100	11	0.57	42	51	11.12	
28		28	100	11	0.57	42	52	1.26	
29		29	100	0	0.57	42	52	1.28	
30		30	100	0	0.57	42	53	1.28	
31		31	99	56	0.5	42	53	1.26	
32		32	99	56	0.49	42	49	1.28	
33		33	99	54	59.42	42	48	59.05	
34	34	99	54	48.54	42	49	11.32		
35	35	99	35	21.65	42	46	15.98		
36	36	99	35	11.64	42	48	43.27		
37	37	99	34	35.11	42	54	56.15		
38	38	99	29	42.51	43	14	8.94		
39	39	99	29	3.31	43	22	38.51		
40	40	99	32	8.62	43	22	43.13		
41	41	99	43	28.84	43	23	54.72		
42	42	99	59	3.61	43	21	39		
43	43	100	3	55.25	43	28	12.32		
44	44	100	42	26.46	43	28	12.32		

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2015 оны 12 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 513

Улаанбаатар
хот

Журам, тооны хязгаар батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 6.5, 9.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан нэг хүүхэд харагчид оногдох хүүхдийн тоог 5 байхаар тогтоосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Сангийн сайд Б.Болор, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л. Гантөмөр, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

Засгийн газрын 2015 оны 513 дугаар
тогтоолын хавсралт

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД САНХҮҮГИЙН
ДЭМЖЛЭГ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүүхэд харах үйлчилгээнд олгох санхүүгийн дэмжлэг (цаашид “санхүүгийн дэмжлэг” гэх)-ийн хэмжээг тооцож төлөвлөх, түүнийг хуваарилах, олгох, зарцуулалтад нь хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Тухайн жилийн дараагийн төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тооны хязгаарыг сургуулийн өмнөх насны хүүхдийн тоо, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо, шинээр ашиглалтад хүлээн авах цэцэрлэгийн тоо, хүүхэд харах үйлчилгээний төв, зөвшөөрөл авсан хүүхэд харагчийн тоо зэргийг харгалзан хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран жил бүрийн 4 дүгээр сард багтаан батална.

1.3. Хүүхэд харагч нь аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс (төв)-ийн даргатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг



хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

1.4. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхэд нь төрийн өмчийн болон төрийн өмчийн бус цэцэрлэгт давхар хамрагдаагүй байна.

Хоёр. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тооцож төлөвлөх

2.1. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тооцож төлөвлөхөд Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж норматив” болон төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн 1 сарын хоолны зардлын Засгийн газраас баталсан жишгийг мөрдөнө.

2.2. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд оногдох хувьсах зардлыг 2 дахин нэмэгдүүлж тооцно.

2.3. Аймаг, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс (газар) нь харьяалах нутаг дэвсгэрт зохион байгуулж байгаа хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгоход шаардагдах хөрөнгийн хэмжээг энэ журмын 1.2-т заасан хүүхдийн тооны хязгаарыг үндэслэн тооцож, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.3-т заасан саналыг хянан нэгтгэж, төсвийн төсөлд тусган хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

2.5. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн хэмжээг хянаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын саналд тусган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Гурав. Санхүүгийн дэмжлэгийг хуваарилах

3.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүүгийн дэмжлэгийг тухайн төсвийн жилийн 1-5 дугаар сар болон 9-12 дугаар саруудад шилжүүлж дууссан байхаар тооцож, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төсвийн сар, улирлын хуваарьт тусгана.

3.2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 1.2-т заасан хүүхдийн тооны хязгаарыг үндэслэн аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс (төв)-т санхүүгийн дэмжлэгийг сар бүр шилжүүлнэ.

Дөрөв. Санхүүгийн дэмжлэг олгох

4.1. Улаанбаатар хот, аймгийн төвийн суманд үйлчилгээ эрхэлж байгаа хүүхэд харагч нь тухайн сард үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн



тоо, ирцийн бүртгэлийн мэдээг хүүхдийн овог, нэр, регистрийн дугаараар гаргаж, дараа сарын 5-ны дотор аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс (төв)-т хүргүүлнэ.

4.2. Аймагийн төвийн сумаас бусад суманд үйлчилгээ эрхэлж байгаа хүүхэд харагч нь энэ журмын 4.1-д заасан мэдээг мөн хэсэгт заасан хугацаанд сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлнэ. Сумын Засаг даргын Тамгын газар мэдээг нэгтгэж, тухайн сарын 10-ны дотор аймагийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэст цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

4.3. Нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо 5-аас бага бол 2 сарын хугацаанд хувь тэнцүүлж санхүүжилт олгох бөгөөд уг байдал 2 сараас илүү хугацаанд үргэлжилсэн тохиолдолд санхүүжилт олгохгүй.

4.4. Аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс (төв) нь энэ журмын 4.1, 4.2-г заасан мэдээг мөн журмын 5.1-д заасан мэдээллийн сантай тулгаж, зөрчилгүй байгаа тохиолдолд сар бүрийн 20-ны дотор санхүүгийн дэмжлэгийг хүүхэд харагчийн харилцах банкны төгрөгийн дансанд шилжүүлнэ.

Тав. Хүүхэд харах үйлчилгээний мэдээлэл, хяналт

5.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн сантай байна. Мэдээллийн санд хүүхэд харагч болон хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн талаарх мэдээллийг дараах байдлаар тусгана:

5.1.1. Хүүхэд харагчийн талаарх мэдээлэл:

- а) овог, эцэг, эхийн нэр, харьяалал;
- б) регистрийн дугаар;
- в) боловсролын түвшинг нотлох баримт бичгийн дугаар, огноо;
- г) хүүхэд харах үйлчилгээний сургалтад хамрагдсаныг нотлох бичиг баримтын дугаар, огноо;
- д) хүүхэд харах үйлчилгээний зөвшөөрөл олгосон сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийн дугаар, огноо;
- е) хүүхэд харах үйлчилгээ эрхлэх байрны хаяг;
- ж) хүүхэд харах үйлчилгээний байр нь хүүхэд харах үйлчилгээний стандартыг хангаж байгааг нотлон олгосон зөвшөөрлийн дугаар, огноо;
- з) холбоо барих утасны дугаар.

5.1.2. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн талаарх мэдээлэл:

- а) овог, эцэг, эхийн нэр, нэр;
- б) регистрийн дугаар;
- в) эцэг, эхийн овог, нэр, тэдний регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар;
- г) хүүхдийн оршин суух хаяг;



д) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дугаар, огноо;

е) цэцэрлэгт хамрагдаагүйг тодорхойлсон баг, хорооны Засаг даргын тодорхойлолт.

5.2. Аймаг, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс (газар) нь хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, олгосон санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл, түүнчлэн хүүхэд харах үйлчилгээнд шинээр нэмэгдсэн болон хасагдсан, оршин суух хаяг нь шилжсэн хүүхдийн тоо, шинээр олгосон болон хүчингүй болгосон үйлчилгээний зөвшөөрлийн тоо болон шаардлагатай бусад мэдээллийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сар бүр хүргүүлнэ.

5.3. Энэ журмын 5.2-т заасан мэдээг сумын Засаг даргын Тамгын газар аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэст, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газарт тус тус хүргүүлнэ.

5.4. Энэ журмын 5.2-т заасан мэдээний маягтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. Тус байгууллага нь хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, төвлөрсөн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын талаар зөвлөмж, аргачлал гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

5.5. Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс (төв) нь аймгийн Боловсрол, соёлын газар, дүүргийн Боловсрол, соёлын хэлтэстэй хамтран хүүхэд харах үйлчилгээ болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн давхардлыг улиралд 1 удаа шалгана. Давхардлыг шалгах журмыг боловсролын болон хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

5.6. Хүүхэд харах үйлчилгээнд зориулан олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтад төрийн болон төрийн бус байгууллага, албан хаагч, эцэг, эх, асран хамгаалагч дараах байдлаар хяналт тавина:

5.6.1. өдөр тутмын байнгын хяналтыг эцэг эх, асран хамгаалагч;

5.6.2. аймаг, нийслэл, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтэс, төвийн ажилтнууд сар, улирлаар төлөвлөн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар болон санал, гомдлын мөрөөр харьяалах нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхэлж байгаа нийт хүүхэд харагч-иргэн, төвүүдийн үйл ажиллагаанд;

5.6.3. хөндлөнгийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага.



Зургаа. Бусад

6.1. Аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс (төв), мэргэжлийн хяналтын байгууллага нь энэ журамд заасан хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй хүүхэд харагч болон төвд олгох санхүүгийн дэмжлэгийг зогсоож, зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.

6.2. Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийг хүүхэд харах үйлчилгээний бүртгэлд оруулсан, сарын мэдээг санаатай буруу мэдүүлсэн албан тушаалтан болон үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоог санаатайгаар буруу мэдээлж санхүүгийн дэмжлэг авсан хүүхэд харагчид Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйл болон Төсвийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 530

Улаанбаатар хот

Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2006 оны 310 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дүрэм”-ийн 14.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.1. Хэрэг эрхлэх газрын шагнал нь “Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “Хүндэт жуух бичиг” мөн бөгөөд уг шагналыг Ерөнхий сайдын захирамжаар бий болгоно. Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл хэрэгт мэдлэг, ур чадвараа дайчлан идэвх зүтгэл гаргаж, үр бүтээлтэй ажилласан төрийн албан хаагчийг “Хүндэт жуух бичиг”-ээр шагнаж урамшуулна.”

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

С.БАЯРЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2016 оны 01 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Шүүх байгуулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 11.35 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Н.Жанцан, Т.Лхагваа, Д.Сугар /илтгэгч/, Д.Наранчимэг, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, Монгол Улсын иргэн О.Баясгалан, Г.Нацагдорж нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг.Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, Хоёр.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, 2 дугаар зүйлийн Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэснийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан үзэж, эцэслэн шийдвэрлэв.

Нэг. Иргэн О.Баясгалан, Г.Нацагдорж нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

“Шүүх байгуулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийн зарим заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн заалтыг зөрчиж байна. Учир нь Үндсэн хуулийн заалт ёсоор аймаг, нийслэл, дүүрэг нь тус бүртээ шүүхтэй байхаар байна.

Үндсэн хуулийг зөрчсөн хэмээн үзэж буй заалттай утга, найруулга адил 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Шүүх байгуулах тухай”



хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Багануур, Багахангай дүүргийн шүүх”, “Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх”, “Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх”, “Хан-Уул, Туул дүүргийн шүүх” гэсэн 1, 3, 5, 7 дахь заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна гэсэн 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар дүгнэлт, 1994 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс тус тус гаргаж байсан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Шүүх байгуулах тухай хууль”-ийн зарим заалтаар “2-3 аймгийн нутаг дэвсгэрийг харьяалуулан дунд нь давж заалдах шатны нэг шүүх байхаар, ... хэд хэдэн дүүргийг нэг шүүхэд ... харьяалуулсан нь шүүхийн үндсэн тогтолцоог үгүйсгэж, иргэний үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах Үндсэн хуулийн суурь зарчим, шүүхийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлсэн Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн” хэмээн үзэж Үндсэн хуулийн цэцээс 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 07 дугаар дүгнэлт гаргаж байсан байна. Уг дүгнэлтийг баталж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр 01 дүгээр тогтоол гаргасан.

Гэтэл Үндсэн хуулийн цэцийн хүчин төгөлдөр шийдвэрийг хууль тогтоогч үл тоон засаг захиргааны нэгжийн дунд шүүх байгуулж урьд өмнө нь гаргаж байсан хоёр ч алдаагаа дахин давтаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн 1-8, 2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн заалтыг зөрчсөн байгаа тул хүчингүй болгож өгнө үү” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Улсын Их Хурлаас Шүүх байгуулах тухай хуулийг батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн холбогдох заалт болон 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Шүүхийн тухай хуулийг эш үндэс болгосон. Тухайлбал, Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын

дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан билээ.

“Шүүхийн тогтолцоо” болон “шүүхийн харьяалал” гэсэн энэ хоёр ойлголт нь онолын өөр ухагдахуунууд юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэгжид шүүх байгуулах асуудал нь шүүхийн тогтолцоонд огт хамааралгүй, харин шүүхийн харьяалал, хүртээмжийн тухай асуудал бөгөөд “шүүхийн тогтолцоо”, “шүүхийн харьяалал” гэсэн ойлголтыг зааглан ойлгох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тайлбарлан хэрэглэх гол сэжиг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгээр тодорхойлсон “шүүхийн үндсэн тогтолцоо” гэсэн ойлголт нь хүний шударга шүүхээр шүүлгэх, давж заалдах үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх тухай билээ.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан уг тогтолцоонд нийцүүлэн тухайн орон нутгийн хүн амын нягтаршил, шүүгчдийн ажлын ачаалал, иргэдэд шүүхийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг асуудлыг харгалзан үзэж, анхан шатны шүүхийг шинэчлэх шаардлагын үндсэн дээр Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас баталсан бөгөөд давж заалдах шатны шүүх нь хэргийн оролцогчийн хүсэлтийг харгалзан тухайн шүүхийн байрших газарт шүүх хуралдааныг явуулж болох бөгөөд шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүгч томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл баталж байхаар хуульчилж өгсөн.

Ингэснээр давж заалдах гомдол гаргах, шүүх хуралдаанд биечлэн оролцох, шударга шүүхээр шүүлгэх иргэний үндсэн эрх, мөн төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах Үндсэн хуулийн үзэл баримтлал, санаа зөрчигдөөгүй болно.

Үндсэн хуулийн дээрх заалтаар шүүхийн тогтолцоог “үндсэн” ба “дагнасан” гэсэн хоёр хэлбэрээр тодорхойлж, шүүхийн үндсэн тогтолцоонд Улсын дээд шүүхээс бусад анхан болон давж заалдах шатны шүүхийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр нэрлэсэн хэдий ч мөн чанараар нь авч үзвэл анхан болон давж заалдах, хяналтын гэсэн гурван шатлалаар хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээр тусгасан. Иргэн шүүхийн шийдвэрийг “давж заалдах эрхтэй”, улмаар анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг “давж заалдах” болон “хяналтын журмаар хянан үзэх”, “бүх шатны шүүх”, “анхан шатны шүүх” гэсэн ойлголт, нэр томъёоноос шүүхийн тогтолцооны үндсэн мөн чанар нь харагдаж байгаа юм.



Дэлхийн бусад улсад ч гэсэн байдаг “ерөнхий шүүгч”, “тусгай шүүх” гэсэн нэршил бүхий нийтлэг жишгийг харгалзан улмаар Үндсэн хуулийн дээрх заалтыг удирдлага болгон Монгол Улсын шүүхийн тогтолцоог “үндсэн”, “дагнасан” гэсэн хоёр хэсгээс бүрдэхээр Шүүхийн тухай хуулиар тодорхойлсон. Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасанчлан “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэх” бөгөөд нийслэлд эрүү, иргэний хэргийн анхан шатны дагнасан шүүхийг байгуулсан нь Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцэж байгаа билээ.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх...” гэснийг зөрчөөгүй, харин Улсын Их Хурал Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн дагуу зарим шүүхийн харьяаллыг шинэчлэн тогтоосон байгааг анхааран үзэж шийдвэрлэхийг Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс хүсэж байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс уг маргаантай холбогдуулан дараах агуулга бүхий тайлбарыг Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн байна. Үүнд:

“Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр “Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх” гэж зөвхөн нэршлийн хувьд аймаг дундын байхаар тусгасан ч агуулгын хувьд давж заалдах шатны шүүхийг аймаг бүрт байгуулахаар тус хуульд тусгаж, “шүүхийн байрших газар”-т баталгаажуулан зохицуулжээ.

Уг хуулийн үзэл баримтлал нь 2013 онд батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн үзэл баримтлалаас агуулгын хувьд өөр бөгөөд өмнөх хуулиар иргэн тойргийн журмаар байгуулагдсан давж заалдах шатны шүүхэд аймаг дамнан очиж маргаанаа шийдвэрлэх агуулгатай байсан бол шинэчлэгдэн батлагдсан уг хуулиар шүүх өөрөө нүүдэллэн ажиллаж, шүүгч томилолтоор ажиллах зэргээр давж заалдах шатны шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, иргэний оршин суугаа аль ч аймагт давж заалдах шатны шүүх хуралдааныг явуулах юм.

Шүүх эрх мэдлийн шинэчлэлийн бодлогын амин сүнс нь шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан байгуулж шүүх, шүүгчийг мэргэшүүлэх, мэргэшсэн шүүгчээр хэрэг маргаанаа хянан шийдвэрлүүлснээр шударга



шүүхээр шүүлгэх хүний үндсэн эрхийн баталгааг илүү баталгаажуулах үзэл баримтлалд тулгуурлан Шүүх байгуулах тухай хуулиар шүүхийг дагнан байгуулсан билээ.

Иймд Шүүх байгуулах тухай хуулийн 1, 2 дугаар зүйлийн холбогдох хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцсэн, хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн үндсэн тогтолцооны зохицуулалтыг зөрчөөгүй, харин хууль тогтоогч Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 3, Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн дагуу шүүхийн харьяаллыг шинэчлэн тогтоосон гэж үзэж байна.” гэжээ.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн дунд суудлын хуралдаанаар энэхүү маргааныг хэлэлцэж 14 дүгээр дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн үндэслэх хэсэгт:

“1. Энэхүү маргаантай агуулгын хувьд адил маргааныг эцэслэн шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 02, 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоол тус тус хүчин төгөлдөр байна. Тодруулбал, холбогдох хуулиар шүүхийг байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтооходоо 2-3 аймгийн дунд нь давж заалдах шатны нэг шүүх байхаар зааж хэд хэдэн дүүргийг нэг шүүхэд харьяалуулсан нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэсэн шийдвэрийг Үндсэн хуулийн цэц өмнө нь гаргасан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн үндсэн тогтолцоогоор аймаг, нийслэл, дүүрэг бүр шүүхтэй байх Үндсэн хуулийн үзэл баримтлалыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх шийдвэрүүдээрээ баталгаажуулсан байна.

2. Шүүх байгуулах тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолд заасан Үндсэн хуулийн зөрчил арилаагүй байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлээр иргэний болон эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийг, 2 дугаар зүйлээр дүүргийн иргэний болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийг байгуулахдаа нэрийн хувьд “аймгийн” болон “дүүргийн” гэж томъёолсон боловч энэ нь 2-3 аймгийн дунд давж заалдах шатны нэг шүүх, 2-3 дүүргийн дунд анхан шатны нэг шүүхтэй байх агуулгыг илэрхийлж байгаа бөгөөд Үндсэн хуульд



бэхжүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллын зарчмаар зохион байгуулагдах Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог үгүйсгэсэн байна.

4. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг.Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт; 2 дугаар зүйлийн Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь иргэний үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах Үндсэн хуулийн суурь зарчмыг алдагдуулж, шүүхийн нэгдсэн тогтолцоог тодорхойлсон Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.” гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурлын “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай” 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 94 дүгээр тогтоолд:

“Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг.Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, 2 дугаар зүйлийн Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Хоёр.Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо ... аймаг ... дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэснийг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 14 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй” гэсэн байна.

Зургаа. Улсын Их Хурлын 2015 оны 94 дүгээр тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр E/23 тоот хориг тавьсан бөгөөд уг хоригийг Улсын Их Хурал 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” 106 дугаар тогтоолоороо хүлээн авсан байна. Энэхүү тогтоолд:

“1. “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийн тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 94 дүгээр тогтоолд тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсугай.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрч 2015 оны 94 дүгээр тогтоолыг



баталсан ба Монгол Улсын Ерөнхийлөгч уг тогтоолд хориг тавихдаа Үндсэн хууль зөрчсөн тухай дүгнэлтийг хөндөөгүй, зөвхөн эдийн засаг, төсвийн хүндрэлтэй байдлыг дурдсан байна.

2. Шүүх байгуулах тухай 1994 оны хуулиар хоёр дүүргийн дунд нэг шүүх байгуулсан, Шүүх байгуулах тухай 2013 оны хуулиар шүүхийг тойргийн зарчмаар байгуулж байсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн 1994 оны 02, 2015 оны 01 дүгээр тогтоол хүчин төгөлдөр байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, 2 дугаар зүйлийн Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо ... аймаг ... дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэснийг зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлт үндэслэлтэй байна.

4. Монгол Улсын Ерөнхийлөгч 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 14 дүгээр дүгнэлтийг хэлэлцэн хүлээн зөвшөөрсөн тухай Монгол Улсын Их Хурлын 2015 оны 94 дүгээр тогтоолд тавьсан хоригийн үндэслэлдээ: “... богино хугацаанд хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломж хомс байгаа ...” гэж тэмдэглэснийг харгалзан үзэх боломжтой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг; 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх гэсэн хэсгийн 1-8 дахь заалт, 2 дугаар зүйлийн Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх гэсэн



хэсгийн 1, 2, 4 дэх заалт, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх гэсэн хэсгийн 1, 2, 4 дэх заалт нь тус тус Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо ... аймаг ... дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэснийг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоолын “Тогтоох” хэсгийн 1 дэх заалтыг 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Ж.АМАРСАНАА
П.ОЧИРБАТ
Н.ЖАНЦАН
Т.ЛХАГВАА
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2016 оны 01 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын 2015 оны
348 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийн ил тод
байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын
зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг
зөрчсөн эсэх маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Ганзориг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн О.Тэнгис, Ц.Монгол, Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын



дарга Д.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор баталсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 2.1.1; 2.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны оршин суугч, иргэн О.Тэнгис Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэлдээ:

"1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор баталсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам"-ын 2.1.1, 2.1.2 дахь заалтууд нь дараах үндэслэлээр Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 2.1.1 дэх заалтад "нуун дарагдуулсан" гэж хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 4.1-д заасны дагуу 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн байхыг ойлгох бөгөөд энэ нь холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны аливаа хяналт шалгалтаар тогтоогдоогүй байхыг;" гэсэн нь доор дурдсан үндэслэлээр хууль бус бөгөөд Монголын иргэн, компаниудад Улсын Их Хурлаас хууль баталж, татварын өршөөл эдлүүлэх эрх олгосныг Засгийн газрын журмаар хязгаарлаж байна. Үүнд:

"Нуун дарагдуулсан" гэдэг үг хэллэг нь заавал түүнийг хяналт шалгалтаар тогтоогоогүй бол "нуун дарагдуулсан" болдог эсхүл төрийн хяналт шалгалтаар тогтоочоор нуун дарагдуулж байгаагүй болдог гэсэн ойлголттой огт холбоогүй юм. Харин ч нуун дарагдуулсан байна гэдгийг хяналт шалгалтаар тогтоож, баримтаар нотолсны дараагаар "нуун дарагдуулсан" байна гэдгийг илрүүлдэг билээ. Иймээс хяналт шалгалтаар "нуун дарагдуулсан"-ыг илрүүлсэн нь нуун дарагдуулсан үйлдэл байсныг ил болгож байгаа болохоос "нуун дарагдуулсан" байсныг "нуун дарагдуулаагүй" болгодог асуудлыг араасаа дагуулахгүй юм. "Нуун дарагдуулсан" гэдэг ойлголт тухайн нуусан зүйлийг хяналт шалгалтаар илрүүлсэн, эсхүл илрүүлээгүйгээс үл хамаарах асуудал бөгөөд энэхүү үйлдлийг гүйцэтгэж буй субъектийн тухайн үйлдэлдээ хандаж буй сэтгэл зүйн байдал буюу субъектив шинжтэй холбоотой ойлголт юм.



Монгол Улсын Их Хурлаас энэхүү хуулийг гаргахдаа “нуун дарагдуулсан” бүх субъектүүдийг хамруулахаар хуульчилсан. Гэтэл дээрх тогтоолоор баталсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 2.1.1 дэх заалтад “Нуун дарагдуулсан” гэсэн нэр томъёог тайлбарлахдаа төрийн байгууллага, албан тушаалтны аливаа хяналт шалгалтаар тогтоогдоогүй байхыг ойлгоно гэсэн нь нийт нуун дарагдуулсан бүх этгээдүүдээс зөвхөн хяналт шалгалтаар илрээгүй этгээдүүдийг хамруулна гэж байгаа нь хуулиар бүгдэд олгосон эрхийг зөвхөн зарим хэсэгт нь хамруулахаар өөрчилсөн нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын Улсын Их Хурал хууль батална гэсэн эрхэд халдаж байна.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.” гэсэн болохоос энэ хуулийн зүйл заалт, үйлчлэх хүрээ, хэмжээг хязгаарлаад хэнийг хуулийн үйлчлэлд хамруулах, хэнийг хамруулахгүйг журмаараа тогтоо гэсэн эрхийг хуулиар Засгийн газарт олгоогүй байна. Нөгөө талаас Улсын Их Хурлаас энэхүү хуулийг батлахдаа “Нуун дарагдуулсан” гэдэгт хамаарах этгээдүүд нь төрийн хяналт шалгалтаар илрээгүй нөхдүүд байна гээд хуульчилчихсан бол өөр хэрэг билээ.

Гэтэл Улсын Их Хурлаас ийм хязгаарлалтыг хуульдаа тогтоогоогүй байхад “Нуун дарагдуулсан” гэдэгт бүх субъектийг хамруулахгүй зөвхөн төрийн хяналт шалгалтаар илрээгүй хэсгийг хамруулна гэсэн нь Засгийн газрын тогтоолоор /журмаар/ хуулийн үйлчлэлийг хязгаарласан асуудлыг бий болгож байна. Энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ ... Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш” гэсэнтэй бүрэн нийцэх юм. Гэтэл Засгийн газар тогтоолоороо хуулийн өмнө бүгд эрх тэгш байх Үндсэн хуулийн үзэл санааг зөрчсөн байна.

Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “ ... хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” эрх нь зөвхөн Улсын дээд шүүхэд байна гэсэн байхад журмынхаа нэр томъёог тайлбарлаж байгаагаар, хуульд буй нэр томъёог тайлбарлах ажиллагааг Засгийн газрын журмаар гүйцэтгэсэн байна.

2. Мөн журмын 2.1.2 дахь заалтад ““хууль хэрэгжих хугацаа” гэж Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль батлагдсан өдөр буюу 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 00.00 цагаас 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 24.00 цаг хүртэлх хугацааг”; гэсэн нь дараах үндэслэлээр хууль бус юм. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай



хууль нь энд заасан хугацаагаар хязгаарлагдахгүй юм. Тухайлбал, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нуусан орлогоо ил болгож тайлан гаргасан этгээдэд 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хойш хэдэн арван жилийн дараа ч акт, торгууль оногдуулж болохгүй юм. Гэтэл Засгийн газраас өөрийн гаргаж буй журмаараа Улсын Их Хурлаас баталсан хуулийн хэрэгжих хугацааг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болохоор, үүнээс цааш хэрэгжих боломжгүй гэсэн хугацаа тогтоож өгснөөрөө Улсын Их Хурлаас баталсан хуулийн үйлчлэлийг дуусгавар болгохоор хуулиас давсан эрх хэмжээ бүхий журам баталж байгаа нь мөн Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэсэн зөвхөн Улсын Их Хуралд олгосон онцгой бүрэн эрхэд халдаж байна.” гэжээ.

Хоёр. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Ц.Монгол Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Засгийн газар 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 348 дугаар тогтоолоор “Эдийн засгийн ил тод байдлын дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг баталжээ. Энд 2.1.1 заалтад “нуун дарагдуулсан” гэдэг ойлголтыг “хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 4.1-д заасны дагуу 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн байхыг ойлгох бөгөөд энэ нь холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны аливаа хяналт шалгалтаар тогтоогдоогүй байхыг” ойлгохоор тайлбарласан байна.

Энэ нь Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “нуун дарагдуулсан” өөрийн өмчлөлийн хөрөнгө гэдгийг тайлбарласан албан ёсны тайлбар болжээ.

Түүнчлэн журмын 2.1.2 дахь заалт нь “хууль хэрэглэх хугацаа” гэдэг ойлголтыг тайлбарласан албан ёсны тайлбар гаргасан байна. “Хууль хэрэгжих хугацаа” гэж Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль батлагдсан өдөр буюу 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 00.00 цагаас 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 24.00 цаг хүртэлх хугацааг,” гэж тодорхойлсон нь “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн тайлбарласан албан ёсны тайлбарын шинжийг агуулсан гэж үзэх үндэслэл бүхий болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 348 дугаар тогтоолоор баталсан Эдийн засгийн ил тод



байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журмын хоёрт нэр томъёоны тодорхойлолт гэсэн 2.1.1, 2.1.2 дахь заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн Засгийн газар төрийн хуулийг биелүүлж; аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх үндсэн бүрэн эрхэд үл хамаарах эрхийг хэрэгжүүлсэн, улмаар Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” Монгол Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд халдсан байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлсэн байна. Үүнд:

“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 -д “Энэ хуулийн зорилт нь хувь хүн, хуулийн этгээд бусдын нэр дээр бүртгүүлсэн, нуун дарагдуулсан өөрийн өмчлөлийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй адилтгах бусад хөрөнгө, олсон орлого, үзүүлсэн үйлчилгээгээ ил тод болгон үнэн зөв, шударгаар санхүү, татварын болон нийгмийн даатгалын тайланд тусгаж, шинээр тайлагнасан, гаалийн байгууллагад нөхөн мэдүүлсэн, улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн байх ба эдгээр үйл ажиллагаа нь хувь хүн, хуулийн этгээдийн зүгээс сайн дурын үндсэн дээр хийгдсэн тохиолдолд тэдгээрийг хуульд заасан хариуцлага болон албан татвараас нэг удаа чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан байна.

Мөн уг хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Энэ хуулийн 3.1-д заасан хугацаанд хөрөнгө, орлогоо сайн дурын үндсэн дээр ил болгон бүртгүүлээгүй, мэдүүлээгүй, тайлагнаагүй хувь хүн, хуулийн этгээдэд энэ хууль үйлчлэхгүй.” гэж хуульчилсан.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн зорилго болон уг хуулийн үйлчлэх хүрээг тогтоосон 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд хувь хүн, хуулийн этгээд нь бусдын нэр дээр бүртгүүлсэн, нуун дарагдуулсан үл хөдлөх хөрөнгө, орлого, үйлчилгээ өөрөө сайн дурын үндсэн дээр ил тод болгон үнэн зөв, шударгаар тайландаа тусгаж, шинээр тайлагнасан, нөхөн мэдүүлсэн, улсын бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд уг хуулийн үйлчлэлд хамаарах нь тодорхой байна.

Гэтэл иргэн О.Тэнгис, Ц.Монгол нар өргөдөл, мэдээлэлдээ “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1.1 дэх заалтыг хууль бус бөгөөд Улсын Их Хурлаас хууль баталж, иргэн, хуулийн этгээдэд татварын өршөөл эдлүүлэх эрх олгосныг Засгийн газрын журмаар хязгаарласан, Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэх зэргээр дүгнэсэн нь үндэслэлгүй байна. Тухайлбал, иргэн О.Тэнгис өргөдөлдөө

“... Улсын Их Хурлаас энэхүү хуулийг гаргахдаа “нуун дарагдуулсан” бүх субъектуудийг хамруулахаар хуульчилсан бол Засгийн газрын журмаар нуун дарагдуулсан бүх этгээдүүдээс зөвхөн хяналт шалгалтаар илрээгүй этгээдүүдийг хамруулна гэж хуулиар бүгдэд олгосон эрхийг зөвхөн зарим хэсэгт нь хамруулахаар өөрчилсөн нь Үндсэн хуулийн 25.1.1-д Улсын Их Хурал хууль батална гэсэн эрхэд халдаж, Улсын Их Хурлын хууль тогтоох эрхийг хязгаарлаж байна” гэжээ.

Харин “Эдийн засгийн ил байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1.1-д уг журамд хэрэглэсэн “нуун дарагдуулсан” гэсэн нэр томъёог хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 4.1-д заасны дагуу 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн байхыг, энэ нь холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны аливаа хяналт шалгалтаар тогтоогдоогүй байхыг ойлгохоор заасан. Энэхүү нэр томъёоны тодорхойлолт нь Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн үзэл баримтлал болон уг хуулийн зорилго, үйлчлэх хүрээг тогтоосон 1.1, 2.2 дахь хэсэгт бүрэн нийцэж байгаа болно.

Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчийн зүгээс иргэн О.Тэнгисийн өргөдөлдөө дурдсанчлан уг хуулийн үйлчлэх хүрээнд хөрөнгө, орлого, үйлчилгээгээ нуун дарагдуулсан бүх этгээд бус, бусдын нэр дээр бүртгүүлсэн, нуун дарагдуулсан үл хөдлөх хөрөнгө, орлого, үйлчилгээг өөрөө сайн дурын үндсэн дээр ил тод болгон үнэн зөв, шударгаар тайландаа тусгаж, шинээр тайлагнасан, нөхөн мэдүүлсэн, улсын бүртгэлд бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээд хамаарахаар хуульчилсан тул хөрөнгө, орлого, үйлчилгээгээ нуун дарагдуулсныг нь хууль, хяналтын байгууллагаас нэгэнт тогтоосон этгээдийг уг хуулийн үйлчлэх хүрээнд хамруулахаар хуулийг хэрэгжүүлэх журамд тусгах боломжгүй юм. Энэ тохиолдолд Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 1.1, 2.1, 3.1, 4.1, 5.1-д заасан хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах гол нөхцөл болох “сайн дурын үндсэн дээр ...” гэсэн шаардлага хангагдахгүй болох нь тодорхой юм.

Үндсэн хуулийн цэцэд нэр бүхий иргэдийн гаргасан өргөдөл, мэдээллээс үзэхэд иргэдийн дунд “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-д хэрэглэсэн дээрх нэр томъёоны талаар зөрүүтэй ойлголт байгаа нь тодорхой болсон тул Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 8 дугаар тогтоолоор “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-д өөрчлөлт оруулж, “хууль хэрэгжих хугацаа” гэсэн нэр томъёог хассан болохыг энэ дашрамд дурдах нь зүйтэй байна.



Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Эдийн засгийн ил тод байдлыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг баталсан. Ийнхүү батлахдаа уг хуулийн үзэл баримтлал, зорилго, зохицуулалтад нийцээгүй асуудлыг журамд тусгаагүй болно.

Хууль тогтоогчийн зүгээс хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг батлах эрхийг тодорхой байгууллага, албан тушаалтанд олгох нь түгээмэл байдаг бөгөөд Засгийн газрын хувьд Улсын Их Хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэх журмыг тогтоолоороо батлан мөрдүүлж байна.

Хуулиар эрх олгосны дагуу Засгийн газар тухайн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг батлахдаа уг журамд хэрэглэсэн нэр томъёог хэрхэн ойлгох талаар тодорхой заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын дагуу Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхийг Улсын дээд шүүх хэрэгжүүлэхээр хуульчилсныг зөрчсөн гэж үзэх үндэслэл биш гэж үзэж байна.

Учир нь энэхүү тодорхойлолт нь тухайн журамд хэрэглэсэн нэр томъёоны тодорхойлолт болохоос хуулийн албан ёсны тайлбар биш юм, Тийм.ч учраас Эдийн засгийн ил тод байдлыг хэрэгжүүлэх журмын холбогдох хэсэгт “Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт”, “2.1.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно” гэх мэтээр заасан бөгөөд түүнд хуулийн албан ёсны тайлбартай холбогдох аливаа зохицуулалт тусгаагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэгч, төрийн гүйцэтгэх дээд байгууллагын хувьд Засгийн газрын шийдвэрийг Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны хувьд тухайн шийдвэрт хэрэглэсэн нэр томъёо салаа утгатай, тодорхойгүй нөхцөлд хэрхэн зөв ойлгож, биелүүлэх билээ. Иймд Улсын Их Хурлаас хуулиар эрх олгосны дагуу баталсан журамд хэрэглэсэн нэр томъёоны тодорхойлолтыг Улсын дээд шүүхийн



хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхэд халдсан мэтээр гуйвуулан тайлбарлаагүй.

Хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн хэм хэмжээний тайлбарыг хэл зүйн, захиргааны, хууль тогтоогчийн хүсэл зоригт тулгуурласан, тоймчилсон, бүдүүвчилсэн, хатуу, тодорхой, заншлын, тодорхой сургааль, номлолд тулгуурласан, түүхэн гэх мэтээр олон төрөлд ангилдаг бөгөөд захиргааны эрх зүйн акт буюу журмын агуулга, утга санааг зөв ойлгож, хэрэглэх талаар баталсан этгээд нь тайлбар, тодорхойлолт гаргах нь түгээмэл явдал.

Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу хувь хүн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр хөрөнгө, орлогоо ил болгож бүртгүүлэх, мэдүүлэх, тайлагнах хугацаа нь уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 2016 оны 02 дугаар сарын 20-ны өдөр дуусгавар болох тул Монгол Улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хувьд хууль тогтоогчоос олгосон бүрэн эрхийн хүрээнд буюу хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн орчны хүрээнд холбогдох журмыг батлан мөрдүүлэх арга хэмжээ авсан гэж үзэж байна.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт дараах агуулга бүхий тайлбарыг ирүүлсэн байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 348 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-аар “нуун дарагдуулсан” гэж шинэ нэр томъёог тодорхойлоогүй Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан эрхийн хүрээнд Засгийн газраас хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг батлан гаргахдаа хуульд байнга хэрэглэгдэж байгаа агуулгыг тухайлбал, тус хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан хуулийн зорилт, 2 дугаар зүйлд заасан хуульд хамрагдах этгээд, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан бүртгүүлэх, мэдүүлэх ажиллагаа, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа ил болгон мэдүүлэх талаарх зохицуулалтуудад заасан “нуун дарагдуулсан” гэснийг журамд нэгтгэн тусгасан болно.

Өөрөөр хэлбэл, хуульд заасан агуулгаас хэтрүүлэн журамлаагүй бөгөөд хуулийг тайлбарлаагүй. Харин хуулийн агуулгыг нийтэд зөвөөр таниулж, хэрэгжүүлэх, хуульд хамруулаагүй харилцааг ялган томъёолох зорилгоор тусгасан. Учир нь нуун дарагдуулсан үйлдэлтэй холбоотойгоор



нуун дарагдуулсан үйлдлийг эрх бүхий этгээдээс тогтоогоогүй, хариуцлага хүлээгээгүй байх /захиргааны акт үйлдэгдээгүй/, нуун дарагдуулсан үйлдлийг эрх бүхий этгээдээс тогтоосон байх, өөрөөр хэлбэл, тогтоогдсон зөрчлийн хүрээнд хариуцлага хүлээлгэсэн байх /захиргааны акт үйлдэгдсэн/ гэсэн эрх зүйн үр дагавар үүсэхээр байна.

Иймд Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хүрээнд нуун дарагдуулсан үйлдлийг хэрхэн авч үзсэнийг харвал:

Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу иргэн, хуулийн этгээд нь сайн дурын үндсэн дээр нуун дарагдуулсан зүйлээ эрх бүхий байгууллагад мэдүүлж, ийнхүү мэдүүлснийхээ төлөө хүлээх ёстой хариуцлагаас чөлөөлөгдөж байгаа юм. Харин эсрэгээр тус хуульд заасан хугацаанаас өмнө эрх бүхий байгууллагын хяналт шалгалтаар нуун дарагдуулсан нь тогтоогдсон буюу ил болсон мэдээллийг бүртгэх асуудал энэ хуульд хамааралгүй байна.

Тухайлбал, татварын харилцааны хувьд авч үзэхэд, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар хуулийн 18.1.1, 18.1.2-т заасны дагуу татвар төлөгч нь өөрөө татвараа тодорхойлж, тайландаа тусгадаг байхаар хуульчилсан. Харин татвар төлөгчийн дээрх өөрөө мэдүүлсэн тайланд татварын албанаас хяналт шалгалт хийж зөрчил илрүүлсэн тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д зааснаар акт үйлдэж, гарсан зөрчил буюу татварын албанд ил болсон тоон дүнгээр татварын албанаас нөхөн ногдуулалт хийж, татвар төлөгчийн тодорхойлсон тайланд өөрчлөлт оруулах замаар мөн хуулийн 55 дугаар зүйлд заасан татварын ер үүсгэн бүртгэдэг. Энэ нь үндсэндээ татварын албанаас албадлагаар нуун дарагдуулсан зүйлийг ил болгон бүртгэж, татвар төлөгчийн тайланд өөрчлөлт оруулах замаар хариуцлага хүлээлгэх ажиллагаа юм.

Иймээс “нуун дарагдуулсан” гэснийг эрх бүхий этгээдийн хяналт шалгалтын хүрээнд тогтоон, албадлагаар нөхөн ногдуулсан буюу хариуцлага хүлээлгэсэн үйлдэлд бус харин иргэн, хуулийн этгээд нь өөрөө сайн дурын үндсэн дээр мэдүүлэх, мэдүүлсний дараа тогтоогдох хариуцлагаас чөлөөлөхөд хэрэглэхээр хуульд заасан бөгөөд ийнхүү заасныг журамд тодотгож өгсөн нь УИХ-ын баталсан хуулийн зохицуулалтыг гажуудуулаагүй бөгөөд хуулийг тайлбарлах бус харин хуульд заасан агуулгыг Засгийн газар эрх хэмжээний хүрээнд журамласан болно.

Нуун дарагдуулсан үйлдэлд хяналт шалгалтаар ил болгосон зөрчлийг хамруулах нь өөрөө хууль тайлбарласан. УИХ-ын хууль батлах эрхийг зөрчсөн шийдвэр болохоор байх тул уг асуудлыг хуулийн хүрээнд нэг мөр журамлах зорилгоор Засгийн газрын тогтоолд тусгасан болно.



Иймд журмын 2.1.1 дахь заалтын “нуун дарагдуулсан” гэх ойлголт нь Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын хууль батлах эрх, Улсын дээд шүүхийн хуульд тайлбар хийх эрх болон хүний эрх тэгш эрхийг зөрчөөгүй болно.” гэжээ.

Тав. Монгол Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад Монгол Улсын дээд шүүх нь “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрхтэй бөгөөд тухайн тайлбарлаж буй хуулийн заалтыг нэг мөр зөв ойлгон хэрэглэх зорилгоор Улсын дээд шүүхээс гаргаж буй энэхүү тайлбар нь албан ёсны, дагаж мөрдөх шинжтэй байдгаараа онцлогтой байна. Улсын дээд шүүхийн тайлбараар хуулийн заалт түүний агуулгыг эрх зүйн үүднээс тайлбарладаг бөгөөд эрх бүхий этгээдээс гаргаж байгаагийн хувьд уг тайлбарыг албан ёсны гэж үздэг. Харин бусад этгээдийн хувийн хуулийн заалт, хэм хэмжээг онолын, шинжлэх ухааны үүднээс тайлбар хийхийг хуулиар хориглоогүй болно. Үүнээс үзэхэд тайлбар гаргаж буй этгээдтэй нь холбогдуулан хуулийн тайлбарыг албан ёсны албан ёсны бус тайлбар гэж ангилж болно.

Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын Засгийн газар нь Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах ажлын хүрээнд хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтэд нь хяналт тавих, хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдээлэл, сургалт, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах эрхтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан нь Засгийн газарт хуулиар олгосон эрхийн хүрээнд хамаарч байна.

Уг журмын 2.1.1 дэх заалтаар Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “... нуун дарагдуулсан ...” гэснийг, журмын 2.1.2 дахь заалтаар хуулийн 4 дүгээр зүйлд заасан “... хуулийн хэрэгжих хугацаа ...” гэснийг тус тус томъёоны болон хэрэгжүүлэх аргачлалын хувьд тодотгон тайлбарлажээ.

Засгийн газар хуульд заасан эрхийн дагуу тогтоол гаргаж, уг тогтоолоор хууль хэрэглэх журмыг баталсан байх ба аливаа журам нь тухайн асуудлыг хэрэгжүүлэх дэс дараалал /процедур/-ыг тогтоодог.



Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг баталж хуулийн зарим заалтын талаар тайлбар тодруулга хийсэн нь нэг талаас хуулийн хэрэгжилт, биелэлтийг нь ханган ажиллах талаар Үндсэн хуулиар олгосон Засгийн газрын бүрэн эрхэд хамаарч байгаагаас гадна, нөгөө талаас дээр дурдсанаар тайлбар гаргаж буй этгээдийн хувьд “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-аар хуулийн зарим заалтыг хэрэглэх талаар тайлбар хийж аргачлал өгсөн нь нь албан бус тайлбар байна.

Иймд Засгийн газрын дээрх үйл ажиллагааг Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах Монгол Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд халдсан гэж үзэхгүй байна.” гэжээ.

Зургаа. Мэдээлэл гаргагч О.Тэнгис Цэцийн дунд суудлын хуралдааны явцад Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор баталсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 2.1.1 дэх заалт нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэснийг зөрчсөн эсэхийг тогтоолгохоор мэдээллийн шаардлагаа нэмэгдүүлэв.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын Засгийн газар нь Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах ажлын хүрээнд хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргах биелэлтэд нь хяналт тавих, хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдээлэл сургалт, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах бүрэн эрхтэй байна.

Монгол Улсын Засгийн газар 2015 оны 348 дугаар тогтоолоор “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан нь Засгийн газарт Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд хамаарч байна.

Уг журамд хэрэглэсэн “нуун дарагдуулсан” гэсэн нэр томъёог хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 4.1-д заасны дагуу 2015 оны 4



дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн байхыг ойлгохоор тайлбарласан нь Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд заасан агуулгад нийцэж байгаа бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасан Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрх, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасан Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд тус тус халдсан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Мөн дээрх журмын 2.1.1 дэх заалтад “... энэ нь холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны аливаа хяналт шалгалтаар тогтоогдоогүй байхыг;” хэмээн тодорхойлсон нь Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан хөрөнгө, олсон орлого, үзүүлсэн үйлчилгээгээ сайн дурын үндсэн дээр ил тод болгон үнэн зөв, шударгаар тайлагнасан, мэдүүлсэн, бүртгүүлсэн байх хуулийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлсэн гэж үзэхээр байна.

Монгол Улсын Засгийн газар 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 8 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт мөн журмын 2.1.2 дахь заалтыг хүчингүй болгосон тул уг заалттай холбогдуулан үүсгэсэн маргаанаар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаас дүгнэлт гаргах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 348 дугаар тогтоолоор батлагдсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1.1 дэх заалтад “нуун дарагдуулсан” гэж хувь хүн, хуулийн этгээд хөрөнгө, орлого, үйл ажиллагаагаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 4.1-д заасны дагуу 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө мэдүүлэх, бүртгүүлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүйн улмаас холбогдох албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй, дутуу төлсөн байхыг ойлгох бөгөөд энэ нь холбогдох төрийн байгууллага, албан тушаалтны аливаа хяналт шалгалтаар тогтоогдоогүй



байхыг” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Д.НАРАНЧИМЭГ
П.ОЧИРБАТ
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Д.ГАНЗОРИГ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 14003